



Хврээлэн байгаа орчин, байгаль дэлхийгээ хамгаалах, жил ирэх тусам осон нэмэгдсээр буй уур амьсгалын дулаарал, хуурайшилт цолжилтийн хурдыг сааруулах, багасгаж бууруулахад нолоолох, эко орчинг бий болгох, ойжуулж цэцэрлэгжүүлэх тухай хаа сайгүй яригддаг ч хэлсэн ярьсан маань ажил хэрэг болох, дээр дурьдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлд дохом үзүүлэх талаар дорвитой үр дүн гарч буй эсэх нь тун эргэлзээтэй.

Судлаачид болон мэргэжлийн хүмүүсийн судлаж тооцоолсноос үзэхэд ирээдүй хойч үеийн маань гэрэл гэгээтэй, сайн сайхан амьдрал хувь заяаны эсрэг хамгийн том “дайсан” нь оноогийн бидний амьдралын чиг хандлага, дадал хэвшил, ойлголт тосоолол ажээ.

Мэргэжилтнүүдийн үгүүлснээр оноодор бидний амьдралын хэрэглээ болсон малтмал

твш, (нввр), шатах тослох материалын шаталт, ойн бүрхэвчийг устгах гэх мэтийн улмаас хэт улаан туяаг шингээн авч, буцаан туяаруулах шинж чанартай нврсхвчлийн хий (CO₂), метан (CH₄), азотын давхар исэл (N₂O), фторт нвврсторогчвүдээс бүрдэх хвлэмжийн хийн агаар мандал дахь агууламж тасралтгүй нэмэгдэн, дэлхийгээс туяарах дулааны цацрагийг дэлхий рүү буцаан ойлгосноор уур амьсгал оорчлогдож, ноцтой асуудлуудыг бий болгосоор. .

Уур амьсгалийн оорчлолтонд дасан зохицох үндэсний хотолборт дурьдсанаас үзэхэд Монгол Улсын хэмжээгээр хвлэмжийн хийн нийт ялгаралт 2006 онд 15,628 мян.тн-CO₂-экв байсан бөгөөд нэг хүнд ногдох хвлэмжийн хийн ялгаралтын хэмжээг авч үзвэл ихэнх хогжиж байгаа орон болон дэлхийн дунджаас ихээхэн дээгүүр үзүүлэлттэйд тооцогдох болжээ.

Дулааралтын улмаас хүнсний бүтээгдэхүүний хадгалалтын горим алдагдах, хэт халуун одрийн тоо нэмэгдсэнээр ходоод, гэдэсний болон суулгалт, зүрх судасны овчлол осох хандлага ихээхэн ажиглагдаж байгааг эрсдэл, аюулын дохио гэхээс аргагүй. Тэрчлэн Монгол оронд 1988 онд зүрх судасны овчлолийн тохиолдлын тоо 10,000 хүн тутамд 100 орчим байсан бол 2008 оны байдлаар 600 орчим болж оссон байна.

Уур амьсгалын дулааралт, хүний вйл ажиллагаанаас үүдэлтэй байгаль орчны доройтол цаашид энэ хурдцаар үргэлжилбэл экологийн томоохон сүйрэлд хүргэж болохын дээр улс орны эдийн засгийн тогтвортой хөгжил, хүн амын эрүүл мэнд, амьжиргаанд ихээхэн сорог нолоо үзүүлэх магадлал улам бүр нэмэгдэх болно хэмээн уг баримт бичигт анхааруулсан байна.



